



НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/562

Улаанбаатар хот

Иргэдтэй хийх уулзалтын хуваарийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг дарга, Засаг даргын орлогч нарын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтад Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ыг мөрдөж ажиллахыг удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Иргэдтэй хийх уулзалтын хуваарь шинэчлэн батлагдаж байгаатай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2017 оны А/95 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.АЛТАНШАГАЙ

1180211340

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2021 оны 09 -р сарын 15 -ны өдрийн
А/562-р захирамжийн хавсралт

ДҮҮРГИЙН УДИРДЛАГА ИРГЭДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАХ ХУВААРЬ

Нэрс	Албан тушаал	Долоо хоног гарг	Цаг
Н.Алтаншагай	Засаг дарга	Пүрэв	09 ⁰⁰ -12 ⁰⁰
Э.Ууганцэцэг	Дүүргийн Засаг даргын Дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч	Пүрэв	09 ⁰⁰ -12 ⁰⁰
Б.Мягмарсүрэн	Дүүргийн Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны төслүүдийн удирдагч-дүүргийн Засаг даргын орлогч	Пүрэв	09 ⁰⁰ -12 ⁰⁰
Т.Вандандорж	Дүүргийн Нийгмийн салбарын төслүүдийн удирдагч-дүүргийн Засаг даргын орлогч	Пүрэв	09 ⁰⁰ -12 ⁰⁰

Тайлбар: Сар бүрийн 1 дэх долоо хоногт Засаг дарга Н.Алтаншагай, 2 дахь долоо хоногт Засаг даргын орлогч Э.Ууганцэцэг, 3 дахь долоо хоногт Засаг даргын орлогч Б.Мягмарсүрэн, 4 дэх долоо хоногт Т.Вандандорж нар дээрх хуваарийн дагуу иргэдтэй уулзана.